

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ ГАЗРЫН
ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ХУУЛИЙН МЭРГЭЖИЛТНИЙ
2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээ

№	Зорилгыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (Биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилго 1. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН ҮНДСЭН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ							
Зорилт 1. Нийслэлийн өмчийн харилцааны менежментийн оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх замаар өмчийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах, эдийн засгийн чадавхыг дээшлүүлнэ.							
1.	Арга хэмжээ 1.1 Нийслэлийн өмчтэй холбоотой шүүхийн маргаанд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргыг төлөөлж оролцох;	Шүүхийн маргааны тоо, Эцэслэн шийдвэрлэсэн маргааны тоо	0%	40%	Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Нийслэлийн Засаг даргыг төлөөлөн оролцож хууль хяналтын байгууллагаар эцэслэн шийдвэрлэгдсэн 4 хэрэг байна. Үүнд: 1) Нэхэмжлэгч: “Анома” ХХК, Хариуцагч: НИТХ, НӨХГ Тус маргааныг ЧД-ийн ИХАШШ-ийн 2020.05.26-ны өдрийн 1239 дүгээр шийдвэр, давж заалдах шатны шүүхийн 2020.09.07-ны 1900 дүгээр магадлал, дээд шүүхийн 2022.09.22-ны өдрийн	02-06	40%

				<p>0839 дүгээр тогтоолоор тус тус шийдвэрлэсэн. Нэхэмжлэгч 2023.09.25-ны өдөр шинээр илэрсэн нөхцөл байдлын улмаас хэргийг дахин хянуулах хүсэлт гаргасан бөгөөд УДШ-ийн 2023.11.07-ны өдрийн 0059 дүгээр тогтоолоор хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн. Улмаар нэхэмжлэгч Үндсэн хуулийн цэцэд 2024.03.22-ны өдөр гомдол гаргаж, Үндсэн хуулийн цэцээс шийдвэрийг хуулийн дагуу хянан хэлэлцэж, шийдвэрийг иргэнд мэдэгдэх талаар УДШ-д мэдэгдсэн. УДШ-ын 2024.06.18-ны өдрийн Д001/хт2024/00148 тогтоолоор ЧД-ийн ИХАШШ-ийн 2020.05.26-ны өдрийн 181/ШШ2020/01239 дүгээр шийдвэрийг хэвээр үлдээж, хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Т.О, өмгөөлөгч А.Н, гуравдагч этгээдийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Х.Б нарын хяналтын журмаар гаргасан гомдлыг хангаж, нэхэмжлэгчийн өмгөөлөгч Л.Х-ын хяналтын журмаар гаргасан гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэсэн. Улсын дээд шүүхээс дээрх тогтоолыг 2025 оны 02 сарын 24-ний өдрийн 06/613 дугаарт албан бичгээр хүлээн авсан. НИТХ-д 186,747,735.0 төгрөгийг “Анома” ХХК төлөхөөр шийдвэрлэсэн байна.</p> <p>2) Нэхэмжлэгч: “Хар чонот” ХХК, Хариуцагч: НИТХ</p> <p>ЧД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2023.04.09-ний өдрийн 1483 дугаар шийдвэрээр НИТХ-аас 1,023,387,350.0 төгрөгийг гаргуулж нэхэмжлэгчид олгож, нэхэмжлэгчийн 456,693,650.0 төгрөгийн нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.</p>	
--	--	--	--	--	--

				<p>Нийслэлийн давж заалдах шатны шүүх 2024 оны 06 сарын 21-ний өдрийн 210/МА2024/01284 дугаарт магадлалаар хариуцагчаас 158,231,567.0 төгрөг гаргуулж, нэхэмжлэгч “Хар чонот” ХХК-д олгож, үлдэх 1,321,849,433.0 төгрөгт холбогдох шаардлагыг хэрэгсэхгүй болгож хариуцагчийн давж заалдах гомдлыг зарим хэсгийг хангаж шийдвэрлэсэн байна. Нэхэмжлэгч тал хяналтын шатны шүүхэд гомдол гаргасан боловч хүлээн авахаас татгалзсан байна.</p>	
				<p>3) Нэхэмжлэгч: “Алаг даага” ХХК, Хариуцагч: НИТХ, НЗДарга</p> <p>Анхан шатны шүүхийн 2022.11.23-ны өдрийн 0173 тогтоолоор нэхэмжлэлийг буцааж шийдвэрлэсэн. Нэхэмжлэгч нар 2023.01.16-ны өдөр тус шаардлагаар дахин нэхэмжлэл гаргасан. Нийслэлийн Засаг даргын А/216 дугаар захирамжийг түдгэлзүүлэх хүсэлт гаргаж Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2023.03.15-ны өдрийн 2486 дугаар шүүгчийн захирамжаар захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлж шийдвэрлэсэн. Давж заалдах шатны шүүх тус шийдвэрийг хэвээр үлдээсэн.</p> <p>”Угалзат дархан” ХХК-аас 2024.01.24-ний өдөр нэхэмжлэлийн шаардлагаа өөрчилсөн тул анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байх хугацаанд нэхэмжлэгчид нэхэмжлэлийн шаардлагаас татгалзсанаар хэрэг хаагдсан байна.</p>	

					<p>4) Нэхэмжлэгч: “ЭХБУТ” ХХК, Хариуцагч: НЗДарга</p> <p>ЧД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 09 сарын 18-ны өдрийн Д182/шш2024/03832 шийдвэрээр “ЭХБУТ”-ийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэв. НИХ-ийн ДЗШШүүхийн 2024 оны 11 сарын 22-ны өдрийн Д 210/МА2024/02008 магадлалаар ЧД-ийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны 09 сарын 18-ны өдрийн Д182/шш2024/03832 шийдвэрийг хэвээр үлдээж, нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн гаргасан давж заалдах гомдлыг хангахгүй орхисон байна. Нэхэмжлэгч Хяналтын шатанд гомдол гаргаагүй хэрэг хаагдсан байна.</p>		
2.	<p>Арга хэмжээ 1.2</p> <p>Нийслэлийн өмчид хохирол учруулсан, үрэгдүүлсэн, шамшигдуулсан, гэрээний заалтыг зөрчсөн зэрэг өмч хөрөнгийн холбогдолтой асуудлыг хяналт шалгалтын байгууллагаар шийдвэрлүүлэх, шүүхийн маргаанд нэхэмжлэгчээр оролцох;</p>	Хөрөнгийн маргааны тоо, дүн, сая төг	0%	35%	<p>Тус газрын балансад бүртгэлтэй, нийслэлийн өмч болох 14 объектой холбоотойгоор өмчлөл, эзэмшлийн асуудлыг шийдвэрлүүлж, хууль бус байж болзошгүй үйлдлийг шалгуулахаар Нийслэлийн Прокурорын газарт өргөдөл, гомдлыг гаргасан. Нийслэлийн Прокурорын газраас дараах асуудлуудыг Авлигын эсрэг гэмт хэргийн шинжтэй байж болзошгүй байдлыг шалгуулахаар Авлигатай тэмцэх газарт шилжүүлэн ажилласан. Үүнд:</p> <p><u>1. Прокурорын тогтоолоор хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан:</u></p> <p>1) Монголын Бурхан Шашинтны шинэ төвийн тэргүүн С.Санждорж нь Сүхбаатар дүүргийн 18 дугаар хорооны нутаг дэвсгэрт байрлах Дамбадаржайлин хийдийн Цогчин дуган А, Б, В блокод Нийслэлийн Өмчийн харилцааны</p>	02-06	35%

					<p>газартай 2010.12.13-2013.12.13, 2014.08.02-2015.08.25-ны хооронд “Нийслэлийн өмчийн барилгад их засвар, хөрөнгө оруулалт хийлгэх тухай байгуулсан гэрээ” гэх гэрээ байгуулж, хөрөнгө оруулалт (засан сайжруулалт) хийсэн бөгөөд барилгыг чөлөөлж, хүлээлгэн өгөхөөс үндэслэлгүй татгалзсан үйлдэлд АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч, комиссар Б.Балдандорж 2024 оны 06 сарын 19-ний өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн 240200420 дугаартай хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулж дуусган хэрэг бүртгэлтийн хэргийг хаах тухай саналыг прокурорт ирүүлснийг, прокурор хянаад хэрэг бүртгэлтийн 240200420 дугаартай хэргийг НПГ-ын 2024 оны 12 сарын 20-ны өдрийн Д392 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.2. дахь заалтад заасан “гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа дууссан” үндэслэлээр хаасан байна.</p>	
					<p>2) Хан-Уул дүүрэг, 3 дугаар хороо “Монгол шуудан” ХК-ийн 36 дугаар салбарын байр нь Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 02/13 дугаар тогтоолоор өмч хувьчлах жагсаалтад орсон ч хувьчлагдаагүй байна. Гэтэл Нийслэлийн өмчийн газрын балансаас ямар нэг шийдвэргүйгээр хасагдсан байгаа нь холбогдох хууль, журам зөрчсөн байдалд АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч, комиссар Б.Балдандорж нь 2024 оны 06</p>	

					<p>сарын 19-ний өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн 240200421 дугаартай хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулж дуусган хэрэг бүртгэлтийн хэргийг хаах тухай саналыг прокурорт ирүүлснийг прокурор хянаад, хэрэг бүртгэлтийн 240200421 дугаартай хэргийг НПГ-ын 2025 оны 01 сарын 20-ны өдрийн Д19 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1. дэх заалтад заасан “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр хаасан байна.</p> <p>3) Баянгол дүүрэг, 7-р хороо, “Эрхэм жаргалан” өрхийн эрүүл мэндийн төвийн хуучин барилга болон Баянгол дүүрэг, 14-р хороо Москва рестораны баруун талд байрлах объектыг тус тус “Тэмүүжин групп” ХХК-д эзэмшүүлж, ашиглуулсан, давхар түрээслэж ашиг олсон үйлдэлд АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч, комиссар Б.Балдандорж нь 2024 оны 06 сарын 19-ний өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн 240200423 дугаартай хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулж дуусган хэрэг бүртгэлтийн хэргийг хаах тухай саналыг прокурорт ирүүлснийг прокурор хянаад, хэрэг бүртгэлтийн 240200423 дугаартай хэргийг НПГ-ын 2025 оны 01 сарын 27-ны өдрийн Д24 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1. дэх заалтад заасан “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр хаасан байна.</p>	
--	--	--	--	--	---	--

					<p>4) Нийслэлийн өмчийн барилга болох Сүхбаатар дүүргийн 2 дугаар хороо, 1а байрны 1 тоотод байрлах өрхийн эмнэлгийн байрыг "Ачит гар" өрхийн эмнэлэг нь "Өмч эзэмшлийн гэрээ"-ээр үнэ төлбөргүй, хууль бусаар эзэмшиж, ашиглаж байсан бөгөөд байрны хийц бүтээцийг зөвшөөрөлгүй өөрчилсөн, байр чөлөөлөхөөс үндэслэлгүй татгалзсан үйлдэлд АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч, комиссар Б.Балдандорж нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн 240200443 дугаартай хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулж дуусган хэрэг бүртгэлтийн хэргийг хаах тухай саналыг прокурорт ирүүлснийг прокурор хянаад, хэрэг бүртгэлтийн 240200443 дугаартай хэргийг НПГ-ын 2025 оны 02 сарын 07-ны өдрийн Д34 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1. дэх заалтад заасан "гэмт хэргийн шинжгүй" үндэслэлээр хаасан байна.</p> <p>5) Ерөнхий сайд Жигжид-жавын байранд "Монгол Улсын Нутгийн удирдлагуудын холбоо" ТББ гэрээгүйгээр үйл ажиллагаа явуулдаг асуудалд АТГ-ын Мөрдөн шалгах хэлтсийн мөрдөгч, комиссар Д.Цогтоо нь 2024 оны 06 сарын 23-ны өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хэрэг бүртгэлтийн 240200427 дугаартай хэрэг нээж мөрдөн шалгах ажиллагаа явуулж дуусган хэрэг бүртгэлтийн хэргийг хаах тухай саналыг прокурорт ирүүлснийг прокурор хянаад, хэрэг</p>		
--	--	--	--	--	--	--	--

					<p>бүртгэлтийн 240200427 дугаартай хэргийг НПГ-ын 2025 оны 02 сарын 07-ны өдрийн Д36 Прокурорын тогтоолоор ЭХХШТХ-ийн 1.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.1. дэх заалтад заасан “гэмт хэргийн шинжгүй” үндэслэлээр хаасан байна.</p>	
					<p>1) Мөрдөн шалгах ажиллагаанд байгаа хэрэг:</p> <p>1) Уламжлалт анагаах ухааны элэг судлалын клиник төвийг Ж.Хатанбаатарт менежментийн гэрээгээр хувьчлахаар гэрээ байгуулж, үйл ажиллагаа явуулсан, нийслэлийн өмчүүдийг эзэмшүүлсэн асуудалд;</p> <p>2) Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, 11-р хороолол, 6-р байр, 2-р орц 40 тоот орон сууцыг Улсын бүртгэл, статистикийн ерөнхий газрын 2016.02.02-ны өдрийн 6/1447 дугаар албан бичгээр Ү-2203012059 дугаартайгаар С.Жамъянжав (ЧВ60062316)-ын өмчлөлд анх төрөөс хувьчилсан. 2005.01.12-ны өдрийн 05 дугаартай нотариатчийн гэрчилсэн Бэлэглэх гэрээгээр иргэн Ш.Дашжамц, Ш.Базарваань нарын өмчлөлд шилжсэн хариу ирсэн. Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, Хүнсчдийн гудамжны 3А, Орбитын орон сууцны дунд байрлах 1 давхар тоосгон барилгын газар болон үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ иргэн С.Батчулууны нэр дээр гарсан. Сонгинохайрхан дүүрэг, 14-р хороо, 1-р хороолол, 14-8-253 тоот орон сууцыг иргэн О.Сүрэнхорлоо Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн Ү-2201020811 гэрчилгээгээр өмчилсөн байна. Баянгол</p>	

					<p>дүүрэг, 14-р хороо, 3 хороолол 18-30 тоот орон сууцыг иргэн П.Цогтбаатар Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн Ү-2205082124 гэрчилгээгээр өмчилсөн нь холбогдох хууль, журам зөрчсөн үйлдэл;</p> <p>3) Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, “Баруун сэлбэ” үйлчилгээний төвийн барилгын “Ж” блокийн зүүн жигүүрт байрлах 1226.96 м² талбайг “Улаанбаатар радио” ХХК-д эзэмшүүлсэн нь хууль, журам зөрчсөн үйлдэл;</p> <p>4) “Нью тур сафарис” ХХК-д өр төлбөрт нийслэлийн өмчийн үнэ цэнэ бүхий объектуудыг өгсөн асуудлыг тус тус шалгаж байна.</p>		
3.	<p>Арга хэмжээ 1.3</p> <p>Өмчийн харилцааны зөрчил маргааныг шүүх, хууль хяналтын байгууллагад хянан шийдвэрлэхэд төлөөлөн оролцох, шүүхэд тайлбар, холбогдох нотлох баримт гаргаж өгөх, мэдээ тайлан гаргах;</p>	<p>Шүүхийн маргааны тоо, Эцэслэн шийдвэрлэсэн маргааны тоо-1</p>	0%	40%	<p>Нийслэлийн өмчийн харилцааны газрыг төлөөлөн оролцож хууль хяналтын байгууллагаар эцэслэн шийдвэрлэгдсэн 1 хэрэг, хууль хяналтын байгууллагад хянагдаж байгаа 6 хэрэг байна. Үүнд:</p> <p>1. Нэхэмжлэгч: НӨХГ, Хариуцагч: “Улаанбаатар Радио” ХХК</p> <p>ЧД-ийн ИХАШШ-ийн 2024.07.22-ны өдрийн 182/ШШ2024/03112 дугаар шийдвэр, НИХ-ийн ДЗШШ-ийн 2024.09.09-ний өдрийн 210/МА2024/01734 дугаар магадлалаар нэхэмжлэлийн шаардлагыг тус тус хангаж шийдвэрлэсэн.</p> <p>Хариуцагч “Улаанбаатар радио” ХХК нь 2024.10.07-ны өдөр хяналтын журмаар Улсын дээд шүүхэд гомдол гаргаж 2024 оны 11 сарын 29-ний өдрийн 001/ШХТ2024/01479 тогтоолоор</p>	02-06	40%

				<p>хариуцагчийн төлөөлөгчийн гомдлыг хэлэлцэхээс татгалзсан байна.</p> <p>2. Нэхэмжлэгч: НӨХГ, Хариуцагч: Б.Ганцогт ХУД-ийн ИХАШШ-ийн 2021.12.10-ны 2905 дугаар шийдвэрээр түрээсийн гэрээний үүрэгт 25,806,600.0 төгрөг гаргуулж, байрнаас албадан чөлөөлүүлэх нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож, сөрөг нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн авахаас татгалзсан. Давж заалдах шатны 2022.03.18-ны 500 дугаар магадлалаар анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр буцаасан. ХУД-ийн ИХАШШ-ийн 2022.06.13-ны 1898 дугаар шийдвэрээр үндсэн нэхэмжлэлээс 9,720,000.0 төгрөг, сөрөг нэхэмжлэлийн шаардлагаас 80,000,000.0 төгрөгийг гаргуулахаар шийдэж, харилцан тооцож нэхэмжлэгчээс 70,280,000.0 төгрөгийг гаргуулан хариуцагчид олгохоор шийдвэрлэсэн. Давж заалдах шатны шүүхийн 2022.09.02-ны 1644 дугаар магадлалаар дээрх шийдвэрийг хүчингүй болгож хэргийг дахин шийдвэрлүүлэхээр буцаасан. ХУД-ийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд 2025 оны 05 сарын 20-ны өдөр шүүх хурал зарлагдсан боловч хариуцагчийн хүсэлтээр 2025 оны 06 сарын 10-ны өдрийг хүртэл шүүх хурлыг хойшлуулсан болно.</p> <p>3. Нэхэмжлэгч: “Материал Имлекс” ХК, Хариуцагч: НӨХГ Анхан шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа үргэлжилж байна. 2024 оны 01 сарын 23-ны өдрийн 181/ШЗ2024/02086 дугаарт захирамжаар</p>	
--	--	--	--	---	--

				<p>хариуцагчаас нотлох баримт гаргуулах зэргээр хойшлуулсан. Нотлох баримтыг 2024 оны 02 сарын 15-ны өдрийн 1/255 албан бичгээр хүргүүлсэн. Одоогоор шүүх хуралдааны тов зарлагдаагүй байна.</p> <p>4. Нэхэмжлэгч: НӨХГ, Хариуцагч: “Ачит гар” ӨЭМТ</p> <p>2025 оны 03 дугаар сарын 07-ны өдөр “Ачит гар” ӨЭМТ нэхэмжлэл гардуулсан. 14 хоногийн дотор шүүхэд хариу тайлбар өгнө гэж Б.Ундраа шүүгчийн туслах Алтантуяагаас 99796002 дугаарт утсаар мэдээлэл авахад шүүхийн ачааллаас хамааран шүүх хурал 2025 оны 08 сард товлогдох талаар хариу өгсөн.</p> <p>5. Нэхэмжлэгч: “Улаанбаатар Радио” ХХК, Хариуцагч: НӨХГ</p> <p>2024 оны 12 дугаар сарын 13-ны өдөр иргэний хэрэг үүсч, 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхээс ирүүлсэн мэдэгдэх хуудсаар “Улаанбаатар радио” ХХК нэхэмжлэлтэй, НӨХГ-т холбогдох иргэний хэргийн шүүх хуралдаан 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр товлогдсон боловч 2025 оны 05 сарын 22-ны өдөр нэхэмжлэгч “Улаанбаатар Радио” ХХК-ийн зүгээс нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсан хүсэлтийг иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд гаргасан байна.</p> <p>6. Нэхэмжлэгч: НӨХГ, Хариуцагч: Г.Алтантуяа</p> <p>Түрээслэгч Г.Алтантуяа нь 2024 онд Нийслэлийн Өмчийн харилцааны газартай байгуулсан Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээний</p>		
--	--	--	--	--	--	--

					<p>төлбөр болох 5,588,100.0 төгрөгийн төлөлтийг хийгээгүй тул тус түрээсийн үлдэгдэл төлбөрийг гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэлийг Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд гаргасан болно.</p> <p>7. Нэхэмжлэгч: НӨХГ, Хариуцагч:”Хоёр сайхан хайрхан” ХХК</p> <p>2024 онд Нийслэлийн Өмчийн харилцааны газартай Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан Хоёр сайхан хайрхан ХХК нь нийт төлөх ёстой байсан түрээсийн төлбөрөөс 1,026,000.0 төгрөгийн төлбөрийг дутуу төлсөн байх тул Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхэд нэхэмжлэл гаргасан болно.</p>		
4.	<p>Арга хэмжээ 1.4</p> <p>Нийслэлийн өмчтэй холбогдон гарсан зөрчил, маргааныг зохицуулах, шийдвэрлэх, учирч болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;</p>	<p>Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь</p>	0%	50%	<ul style="list-style-type: none"> Энэ арга хэмжээний хүрээнд Нийслэлийн прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн дарга Х.Батчимэг, прокурор Б.Болортуяа нартай уулзалт хийж, нийслэлийн өмчит хуулийн этгээдийн ашиглалтгүй болон илүүдэлтэй ажлын байр, талбай, хөдлөх хөрөнгийн түрээсийн гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдээс үлдэгдэл төлбөрийг нэхэмжлэх, шүүхэд үлдэгдэл төлбөрийг гаргуулах шаардлага бүхий нэхэмжлэл гаргах ажлуудыг шат дараалан хэрэгжүүлэх ажлын хүрээнд хамтран ажиллан, төр нийтийн ашиг сонирхолыг хамгаалж өгөхийг хүссэн 1/765 дугаар албан бичгийг 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр хүргүүлэн ажилласан. 	02-06	50%

					<ul style="list-style-type: none"> Энэхүү ажлын үр дүнд нийслэлийн төсөвт хөрөнгө төвлөрүүлэх ач холбогдолтой юм. 		
5.	<p>Арга хэмжээ 1.5 Холбогдох хууль тогтоомжийн төсөлд санал оруулах, өмчтэй холбоотой хууль, дүрэм, журмыг сурталчлан, арга зүйгээр хангах;</p>	Санал өгсөн хуулийн тоо -7	0%	50%	<ul style="list-style-type: none"> 1) <u>1/515/2025-03-31/</u> Орон сууцны болон орон сууцны бус зориулалттай байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн менежментийн тухай хууль 2) <u>1/723/2025-05-07/</u> Худалдан авах ажиллагааны тухай хууль 3) <u>1/729/2025-05-07/</u> Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль 4) <u>1/752/2025-05-13/</u> Арилжааны тухай хууль 5) <u>1/773/2025-05-14/</u> “Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын тогтолцоо, шийдвэр гүйцэтгэгчийн эрх зүйн байдлын тухай, Иргэний болон захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай, Эрүүгийн болон зөрчлийн хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль”-ийн төсөл; 6) <u>1/653/2025-04-21/</u> Нийтийн өмчийн тухай хуулийн төсөл; 7) <u>1/800/2025-05-22/</u> Дулаан хангамжийн тухай хуулийн төсөл; 	02-06	50%
6.	<p>Арга хэмжээ 1.6 НИТХ-ын тогтоол, нийслэлийн Засаг даргын захирамжаар батлагдан нийслэлийн хэмжээнд дагаж мөрдөж байгаа</p>	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0%	40%	Тухайн төлөвлөгөөний дагуу хийгдсэн ажил байхгүй байна.	02-06	-

	нийслэлийн өмчийн эрх зүйн акт, дүрэм, тогтоол, журмуудад холбогдох нэмэлт, өөрчлөлтийг оруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулах;						
Зорилт 2. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, эрх зүйн баримтуудыг шинэчлэн боловсруулна.							
7.	Арга хэмжээ 2.1 Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн зүйл, заалтын хэрэгжилтийг ханган ажиллах;	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0%	50%	Байгууллагын үйл ажиллагааг хангах зорилгоор батлан гаргаж байгаа дараах баримт бичгийн төслийг өдөр тутам хянаж, хууль зүйн үндэслэлийг зөв бичих, жигдрүүлэхэд анхаарч, албан хаагчдыг хууль зүйн зөвлөгөө мэдээллээр тогтмол ханган ажиллаж байна. Хянасан гэрээ болон тушаалын тоог харуулбал: I. Гэрээ-141 - Шууд гэрээ (15) - Дам гэрээ (92) - Үдийн цайны газрын гэрээ (34) II. Тушаал-41 Б тушаал (41)	02-06	50%
8.	Арга хэмжээ 2.2 Хяналт шалгалтын байгууллага, дээд байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах;	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0%	50%	1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 1/798 дугаарт албан бичгээр “2025 оны эхний хагас улиралд хийсэн эрх зүйн үйл ажиллагааны тайлан” илгээсэн.	05	50%
Зорилт 3. Албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулах, баримт бичгийн эмх цэгц, бүрдэл, хадгалалт, ашиглалтыг сайжруулна.							
9.	Арга хэмжээ 3.1 Архив албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, холбогдох дүрэм, журам болон стандартыг албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мөрдөн ажиллаж,	Боловсруулсан албан бичгийн тоо-32 Боловсруулсан гэрээний төсөл-5	0%	50%	1. Монгол бичгийн ур чадвар дээшлүүлэх хичээлд хамрагдсан. 2. Нийт 32 албан бичгийг шийдвэрлэсэн. https://edoc.ulaanbaatar.mn/#/Screen/ED10038/1748325087 3. Харуул хамгаалалтын гэрээ- 4 - <i>Эмнэлгийн зориулалт бүхий объект</i>	02-06	50%

	монгол бичгийн ур чадвараа дээшлүүлэн, албан хэргийг хос бичгээр хөтлөн, албан бичиг, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэх;				<ul style="list-style-type: none"> - Шар хоолойн Их ам-3-т байрлах объект - Эмийн үйлдвэрийн барилга - Сувилал эмчилгээний зориулалт бүхий объект <p>Мэргэжилтэн Номундалайтай хамтран "Хөрөнгийн үнэлгээ хийх ажил гүйцэтгэх гэрээ"-ний төслийг боловсруулсан.</p>		
10.	Арга хэмжээ 3.2 Архивын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж, байгууллагын архивын сан хөмрөгийг бүрдүүлэх;	Архивласан материалын тоо-1	0%	50%	Архив албан хэрэг хөтлөлтийн журам шинэчлэгдсэн ба Хүний нөөцийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан сургалтад хамрагдаж, оновчтой мэдээллийг олж авсан бөгөөд "Хар чонот" ХХК-тай холбогдох материалыг архивласан болно.	04-05	50%
Зорилго 2. ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАН ХААГЧИЙН НИЙТЛЭГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЖ АЖИЛЛАХ							
Зорилт 1. Нийслэлийн өмчийн харилцааны менежментийн оновчтой бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх замаар өмчийн үр ашиг, өгөөжийг нэмэгдүүлэх, ашиглалтыг сайжруулах, эдийн засгийн чадавхыг дээшлүүлнэ.							
11.	Арга хэмжээ 4.1 Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн комисст орж ажиллах;	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0%	45%	Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах дараах ажлын хэсгийн комисст нарийн бичгийн даргын үүргээр орж ажилласан. Үүнд: 1. Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын Тамгын газрын Нутгийн захиргааны нэгдсэн байрны 9 дүгээр давхарт байрлах 207.63 м.кв "Цайны газар"-ын зориулалттай талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комисс; 2. Нийслэлийн Ерөнхий боловсролын 168 дугаар сургуулийн 1 давхарт байрлах 353.5 м.кв "Сургуулийн цайны газар"-ын зориулалттай талбайг түрээслэх түрээслэгчийг болон "Үдийн хоол" хөтөлбөрийг хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах комисс;	02-06	45%

				<p>3. Нийслэлийн Өргөө амаржих газрын байранд байрлах 172.1 м.кв талбайг "Цайны газар"-ын зориулалтаар түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комисс;</p> <p>4. Нийтийн тээврийн бодлогын газрын баланст бүртгэлтэй Шархадны автобусны буудлын эцсийн зогсоолын 96.9 м.кв талбайг болон Улиастайн автобусны буудлын эцсийн зогсоолын 136 м.кв талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комисс;</p> <p>5. Хүрээ амаржих газрын шинэ эмнэлгийн барилгын гадна байрлах 30 авто машины зогсоол бүхий 288 м.кв "Авто машины зогсоол"-ын зориулалттай талбайг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комисс;</p>		
				<p>Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг иргэн, хуулийн этгээдэд түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах дараах ажлын хэсгийн комисст гишүүний үүргээр орж ажилласан. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> 1. Мөн Сүхбаатар дүүргийн 6 хорооны нутаг дэвсгэрт байршилтай Нийслэлийн Өмчийн харилцааны газрын балансад бүртгэлтэй "Сувилал, сургалт эрдэм шинжилгээний судалгааны төв"-ийг үнэлэх үнэлгээний байгууллагыг сонгон шалгаруулах комиссын гишүүн; 2. Нийслэлийн өмчийн 4 объектийг хамгаалалтад авах хамгаалалтын компанийг сонгон шалгаруулах комиссын гишүүн; 3. Хан Уул дүүргийн Эрүүл мэндийн төвийн эмийн сангийн зориулалтаар түрээслэх түрээслэгчийг сонгон шалгаруулах комисс-д гишүүнээр тус тус оролцоод байна. 		

Зорилт 2. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллаж, эрх зүйн баримтуудыг шинэчлэн боловсруулна.

12.	Арга хэмжээ 5.1 2025 оны нийслэлийн “Бүтээн байгуулалтын жил”-ийн жилийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллах;	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0%	50%	2025 оны 03 дугаар сарын 28-ны 02-02/1865 дугаартай албан бичгээр ирүүлсэн Нийслэл хотод хэрэгжүүлэх 24 мега төслийн танилцуулгын хүрээнд албан хаагчид болон олон нийтэд үнэн, зөв мэдээллийг үе шаттайгаар танилцуулж, хэрэгжилтийн тайланг 2025 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн дотор Нийслэлийн Засаг Даргын тамгын газарт хүргүүлсэн болно.	03-04	50%
13.	Арга хэмжээ 5.2 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд хавар, намар мод тарих;	Модны тоо, Өртөг, сая төг	0%	-	2025 оны 05 дугаар 10-ны өдөр Нийслэлийн Өмчийн харилцааны газар мод тарих аянд оролцсон. Миний бие тус өдөр хичээлтэй байсан тул мод тарих ажлын төсөвт хувь нэмрээ оруулсан.	05	-

Зорилт 3. Мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл технологийг сайжруулна.

14.	Арга хэмжээ 6.1 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийг ханган ажиллах;	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0%	50%	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт зааснаар нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гэж ангилсан байна. Тус хуулийн 7.2-т “Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг нээлттэй мэдээлэл гэж үзнэ” гэж заасан байдаг. Иймд өдөр тутмын үйл ажиллагаандаа хязгаарлалттай болон хаалттайгаас бусад мэдээллийг иргэдэд ил тод, нээлттэй өгч ажиллаж байна. Нийслэлийн Өмчийн харилцааны газрын https://www.umch.ub.gov.mn/ албан ёсны цахим хуудасны Хууль эрх зүй цэсэнд байрлах хууль, журам, дүрмийн жагсаалтыг холбогдох мэргэжилтэнд гаргаж өгсөн. Мөн цахим хуудсыг мэдээллээр хангах ажлыг цаг тухай бүрт хийж гүйцэтгэж байна.	02-06	50%
-----	---	-----------------------------------	----	-----	--	-------	-----

Зорилт 4. Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллаар хангана.

15.	Арга хэмжээ 7.1 2025 оны төлөвлөгөөг тайлагнах;	гүйцэтгэлийн батлуулах,	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0%	50%	2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг бэлтгэж, Хууль зүйн хэлтсийн дарга Б.Баясалмаа баталсан болно. Мөн 2025 оны хагас жилийн тайланг бэлтгэсэн болно.	02-12	50%
-----	--	-------------------------	-----------------------------------	----	-----	---	-------	-----

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

№	Зорилгыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (Биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.	<p>Арга хэмжээ 1.1</p> <p>Албан хаагчийн албан үүргээ мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилтын хүрээнд зохион байгуулсан сургалт, семинар, олон нийтийн ажилд оролцох;</p>	Сургалт, семинар-14	0%	50%	<p>Төрийн албан хаагчын хувьд Нийслэлийн хүний нөөц хөгжлийн төвөөс зохион байгуулж буй сургалтуудад идэвхтэй хамрагдаж байна.</p> <p>1) <u>Долоо хоног бүр цахимаар тогтмол</u> Төрийн албаны зөвлөлөөс цахим хэлбэрээр зохион байгуулдаг 7:4:10 сургалтууд</p> <p>2) <u>2025-04-11 цахимаар</u> “Бүтээмж ба шийдэл” мэтгэлцээний 4 дүгээр тэмцээний техникийн зөвлөгөөн, сургалт;</p> <p>Төрийн албан хаагчын хувьд Нийслэлийн хүний нөөц хөгжлийн төвөөс зохион байгуулж буй сургалтуудад идэвхтэй хамрагдаж байна.</p> <p>3) <u>2025-04-23 танхимаар</u> Архив, албан хэрэг хөтлөлтийн сургалт;</p> <p>4) <u>2025-03-25 танхимаар</u> Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хуулийн хэлтсийн албан хаагчдад зориулсан “Захиргааны шийдвэр ба хүний эрх, Нийслэлийн нутаг дэвсгэрт худалдаа, үйлчилгээ эрхлэх нийтлэг журам талаар ойлголт олгох, хэрэгжилтийг хангах” зорилготойгоор зохион байгуулсан 8 цагийн сургалт ;</p> <p>5) <u>2025-04-30 танхимаар</u></p>	03-06	70%

					<p>Нийслэлийн Засаг захиргааны нэгжийн шинэчлэл ба Хот тосгоны эрх зүйн байдлын хуулийн танилцуулга сургалт;</p> <p>6) <u>2025-04-30 танхимаар</u> 4 жилийн стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах хүрээнд албан хаагчдад хийх сургалт;</p> <p>7) <u>2025-04-19 танхимаар</u> “Бүтээмж ба шийдэл” мэтгэлцээний 4 дүгээр тэмцээнд гуравдугаар байр;</p> <p>8) <u>2025-05-13-14 танхимаар</u> Шинэтгэлээр түүчээлсэн салбар зөвлөл аяны хүрээнд нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын хэмжээнд төрийн албанд шинээр томилогдсон албан хаагчид ажлын чиг баримжаа олгох, дасан зохицоход дэмжлэг үзүүлэх, дадлагажуулах соёлыг төлөвшүүлэх зорилгоор зохион байгуулсан 16 цагийн чиглүүлэх сургалтуудад тус тус хамрагдсан болно. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Архив, албан хэрэг хөтлөлт, Үндэсний бичгээр бичих арга зүй; - E-Doc, ERP, Өргөдөл гомдлын системийн хэрэглээ; - Хууль эрх зүй- Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжийн хэрэглээ; - Хөгжлийн бодлогын баримт бичгийн төлөвлөлт, тайлагналт; - Төрийн албан хаагчийн ажлын зохион байгуулалт, харилцааны соёл; - Цахим орчны боломж ашиглан ажлын бүтээмжээ нэмэгдүүлэх нь; - Төрийн албан хаагчийн ёс зүй, хариуцлага; 	
--	--	--	--	--	---	--

2.	Арга хэмжээ 1.2 Англи хэлний түвшин ахиулах сургалтад хамрагдах;	Сургалтад бүрэн хамрагдаж, шалгалт өгөх.			Абсолют англи хэлний сургалтын төвд IELTS-ийн ангид суралцаж байна.	2025.02.27	-
----	---	--	--	--	---	------------	---

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь
1.	Үүрэг даалгавар 1. Хяналт, шалгалтын ажлын хэсгийн нарийн бичгийн дарга	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	0%	100%	Нийслэлийн Өмчийн харилцааны газрын даргын А/82 дугаар тушаалаар байгуулагдсан хяналт, шалгалт хийх чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнд нарийн бичгийн даргын чиг үүргээр оролцож байна. Тул ажлын хэсгийн бүрэлдэхүүн нь 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн “Олон улсын худалдаа логистикийн төв” ХК-д хяналт, шалгалтыг хийж байна.	2025.05.23	-

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ
ГАЗРЫН ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
МЭРГЭЖИЛТЭН

(Абан тушаал)

Б.НАНДИН-ЭРДЭНЭ / *Б.Нандин-Эрдэнэ* /

(Нэр, гарын үсэг)

2025 05 28

(Огноо)

ХЯНАН БАТАЛГААЖУУЛСАН:

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН ХАРИЛЦААНЫ
ГАЗРЫН ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

(Абан тушаал)

Б.БАЯСАЛМАА / *Б.Баясалмаа* /

(Нэр, гарын үсэг)

2025 05 28

(Огноо)

---oOo---